МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.01.31 № 06

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Хуулийн хэрэгжилтийн талаар

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн”, “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт хуримтлалын сангийн орлого дараах хоёр төрлийн эх үүсвэртэй байна гэж хуульчилсан. Үүнд “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг”, “... төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ногдол ашиг” хамаарч байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар ашигт малтмалын 16 орд газрыг стратегийн ордод хамааруулж, хоёрдугаар хавсралтаар стратегийн ордод хамааруулж болох 39 ашигт малтмалын орд газрыг судлан шийдвэрлэхийг тухайн үеийн Засгийн газарт даалгаж баталсан.

Гэвч уг тогтоолоор баталгаажуулсан 16 стратегийн, 39 стратегийн ордод хамааруулж болох ашигт малтмалын орд газруудын цөөн хэд нь Монгол Улсын төр, ард түмэнд үр өгөөжөө хүртээж байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн”, 5.4 дэх хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний

2025009907

үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно", мөн 5.5 дахь хэсэгт "Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно" гэж заасан.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т "Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах, хасах" гэж Улсын Их хурлын бүрэн эрхийг, 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж Засгийн газрын бүрэн эрхийг хуульчилсан байна.

3. Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан. Уг хуульд өмнөх хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Монгол Улсын хилийн тухай хуулиас өөр шинэ зохицуулалт тусгасан байна.

Хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь хэсэгт "улсын хилийн зурваст хил хамгаалалтын зориулалттайгаас бусад барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах асуудлыг Засгийн газар шийдвэрлэх" гэсэн заалт 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн батлагдсан Монгол Улсын Хилийн тухай хуульд байгаагүй билээ.

Дээрх асуудлуудын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

1. Байгалийн баялгийн үр өгөөжийг нийт иргэдэд хүртээх агуулга, зорилго бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг; Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэг;

2. Ашигт малтмалын орд газарт төр өөрийн оролцоог бий болгож хувь хүртэх тухай Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4, 5.5 дахь хэсэг;

3. Ашигт малтмалын Стратегийн орд газрын тоог нэмэх үйл ажиллагааг зохицуулсан Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэг;

4. Монгол Улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь хэсэг;

2025090907

5. Стратегийн орд газрыг тогтоосон, нэмэгдүүлэх боломжийг судлахыг даалгасан утга бүхий Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоол зэрэг хууль тогтоомжуудын хэрэгжилт, хүрсэн үр дүнгийн талаар мөн улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийгдсэн ашигт малтмалын ордуудын талаар, стратегийн орд газрууд хэрхэн хувийн хэвшлийн эзэмшилд шилжиж очсон, Стратегийн ордын тоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлууд, Үндэсний баялгийн сангийн хуримтлалын эх үүсвэрийг бүрдүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөж буй ажлын талаар.

Дээрх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 “Асуулгыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуулгын хариуг хугацаа хожимдуулж ирүүлсэн, эсхүл ирүүлээгүй бол асуулга тавьсан гишүүн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналаа энэ хуулийн 57.10-т заасан Байнгын хороонд хүргүүлж болно” гэж заасны дагуу ирүүлэхийг танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ө.ШИЖИР

2025000007